



ӨВӨРХАНГАЙ ЛЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/119

Хужирт сум

Хязгаарлалтын дэглэмд
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1, 18 дугаар зүйлийн 18.1, 18.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам"-ын 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Тус сумын Дулаан 6 дугаар багийн нутагт 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс хойш бог малын мялзан өвчний шинж тэмдэг илрээгүй тул сумын Засаг даргын "Хорио цээрийн дэглэм тогтох тухай" А/101 дүгээр захирамжийг цуцалж, 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт байгаа малтай өрхүүдийн малд тандалт шинжилгээ хийж, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга Б.Ичинхоролцэвэлмаа, 6 дугаар багийн Засаг дарга Ц.Амгалан нарт үүрэг болгосугай.

3. Хязгаарлалтын дэглэмийн үеэр хөдөлгөөнт эргүүл гаргаж техник хэрэгсэл, хүн хүч дайчлан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга З.Цэцэгмаа, шаардагдах шатах тослох материал, халдвар хамгааллын хувцас, халдваргүйжүүлэлтийн бодисоор хангаж ажиллахыг Нягтлан бодогч Г.Оюунмандахад даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч Б.Дэмбэрэлд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ